

“Эм Жи Эл Акуа” ХК-ийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

(2025 оны дөрөвдүгээр улирал)


1. Ерөнхий мэдээлэл

“Эм Жи Эл Акуа” ХК нь IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгийг компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд ашиглахаар төлөвлөсөн.

2024 оны 5 дугаар сарын 31-ний өдөр нийт 15,234,677,184 (арван таван тэрбум хоёр зуун гучин дөрвөн сая зургаан зуун далан долоон мянга нэг зуун ная дөрвөн) төгрөгийг IPO-оор амжилттай татан төвлөрүүлж, компанийн банкны дансанд хүлээн авсан болно.

2. Хөрөнгийн зарцуулалт

Зураг 1. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө



Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт дараах байдлаар хийгдсэн байна.

2.1. Түүхий эд, материалын худалдан авалт

IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 4,116,812,809 төгрөгийг түүхий эд, материал (ТЭМ) худалдан авахад зарцуулсан бөгөөд уг зардлыг 2024 онд бүрэн санхүүжүүлж дуусгасан.

2.2. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, трансформаторын худалдан авалт

2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр том савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугам худалдан авахад 4,500,000,000 төгрөг, трансформатор худалдан авахад 550,000,000 төгрөг тус тус зарцуулсан (Зураг 1). Трансформаторыг 2025 оны дөрөвдүгээр улиралд суурилуулж дууссан.

Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эхний багц болох цэвэршүүлэх (филтер) шугамыг 2025 оны 5 дугаар сарын 3-наас 5 дугаар сарын 23-ны хооронд суурилуулсан. Өмнөговийн үйлдвэрийн төслийг ашиглалтанд орох үед Улаанбаатар үйлдвэрийн шугамын тоног төхөөрөмжийг Өмнөговь үйлдвэр лүү шилжүүлнэ. Үүний дараа том савлагааны үйлдвэрлэлийн шугамын үлдсэн тоног төхөөрөмжийг 2026 оны 04 сарын 30 дотор суурилуулж дуусгана.

2.3. Орон нутгийн үйлдвэрийн төсөл

“Эм Жи Эл Акуа” ХК-ийн Орон нутгийн савласан цэвэр усны үйлдвэрийн ерөнхий гүйцэтгэгчийг 2025.04 сард шалгаруулсан. Барилгын ажил төлөвлөгөөний дагуу суурийн ажил, гадна ханын өрлөг шавар, гадна сэндвич, хана угсралт, дотор бохир, тэгшилгээ, шал цутгалтын ажлууд хийгдэж байна.

2025 оны 09 дугаар сарын 30-ний байдлаар орон нутгийн үйлдвэрийн төсөлд IPO-оос татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 6,067,863,875 төгрөг, компанийн өөрийн орлогоос 70,138,125 төгрөг тус тус зарцуулсан байна.

Орон нутгийн төслийн барилга угсралтын ажлын явц:

- Газар шороо суурийн ажил, карказ дууссан 100%
- Гадна хананы өрлөг шавар, гадна сэндвич хана угсралт дууссан 100%
- Дээврийн сэндвич угсралтын ажил дууссан 100%
- Дотор бохир, шал, дотор дулааны шугам угсралтын ажил дууссан 100%
- Дотор цахилгааны ажил 70%

Барилга угсралтын ажил шинэчилсэн графикийн дагуу хэвийн явагдаж байна (Зураг 2).



Зураг 2.

3. IPO хөрөнгийн зарцуулалттай холбоотой хугацаа хойшлох шалтгаан

Орон нутагт савласан цэвэр усны үйлдвэр барих төсөл нь анхны төлөвлөгөөний дагуу 2025 онд ашиглалтад орохоор тусгагдсан байсан ч дараах бодит шалтгаануудын улмаас хэрэгжилтийн хугацаа хойшлогдсон. Үүнд:

3.1. Усны нөөцийн хайгуулын хугацаа сунжирсан

Өмнөговь аймагт усны геофизикийн болон гидрогеологийн хайгуулын судалгаанууд нь олон үе шаттай, цаг хугацаа шаардсан үйл явц бөгөөд зөвшөөрөл олголт, үр дүнг баталгаажуулах ажиллагаа хойшилсон.

3.2. Байгаль орчны үнэлгээтэй холбоотой шаардлагууд

Усны хайгуулын дараах байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийх үйл явц нь урьдчилан тооцоолсноос удааширсан.

3.3. Зураг төсөл, тендер шалгаруулалтын хугацаа

Үйлдвэрийн барилга, дэд бүтцийн зураг төслийг батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа цаг хугацаа авч, графикаас хоцорсон.

3.4. Орон нутгийн захиргаатай хамтран ажиллах, зөвшөөрөл авах үе шат удааширсан

Төсөлтэй холбоотой зөвшөөрөл, дэмжлэгийг орон нутгийн байгууллагуудаас авах явцад тодорхой хугацааны зөрүү гарсан.

Одоогоор төслийн хэрэгжилт шинэчлэгдсэн графикийн дагуу хэвийн үргэлжилж байна.